



## МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2014 оны 07 сарын 10 өдөр


Дугаар 4/253

Улаанбаатар хот


Г Түр журам батлах тухай Т

МУИС-ийн Захиргааны зөвлөлийн 2014 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

- “Монгол Улсын Их Сургуулийн магистр, докторын хөтөлбөрт оюутан элсүүлэх түр журам”-ыг хавсралтаар баталсугай.
- Журмыг 2014-2015 оны хичээлийн жилийн намрын элсэлтээс эхлэн мөрдөж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Сургалтын нэгдсэн алба /Ч.Ундрам/, Мэдээллийн технологийн алба /Ш.Содбилэг/, бүрэлдэхүүн сургуулийн захирал, сургалтын албаны эрхлэгч наарт үүрэг болгосугай.



Д-р.А.ГАЛТБАЯР



## МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН МАГИСТР, ДОКТОРЫН ХӨТӨЛБӨРТ ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ТҮРЖУРАМ

### ТАНЫ АНХААРАЛД:

*БШУЯ-наас их дээд сургуулийн магистр, докторын түвшний мэргэжлийн нэр, индексийг шинэчлэн батлах гэж байгаа болон МУИС-ийн сургалтын шинэчлэлэй холбогдоно энэхүү түр журмын зарим зүйл заалт тухайлбал, МУИС-ийн бүртгэхүүн сургуулиудаас санал болгож байгаа магистр, докторын үндсэн мэргэжлийн хотолборуудийн нэрс урьдчилсан байдлаар гарсан болохыг анхаарна уу. Форчлолт орсон тохиолдолд зохих мэдээллийг МУИС-ийн цахим мэдээллийн системээр тухай бүр хүргэнэ.*

### 1. Ерөнхий зүйл

- 1.1. МУИС-ийн магистр, докторын хөтөлбөрт 2014 онд оюутан элсүүлэхэд БСШУ-ы сайдын 2007/187 дугаар тушаалаар баталсан “Магистр докторын сургалт эрхлэхэд баримтлах нийтлэг журам”, МУИС-ийн захирлын 2012/425 тоот тушаалаар баталсан “МУИС-ийн Төгсөлтийн дараах сургуулийн сургалтын журам” болон энэхүү журмыг (цаашид журам гэнэ) баримтална.
- 1.2. МУИС-ийн магистрын өдөр, докторын өдөр, эчнээ, экстернат хөтөлбөрт элсэхээр бүртгүүлэгч, элсэгч болон элсэлтийн комиссын үйл ажиллагааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.
- 1.3. МУИС-ийн магистр, докторын хөтөлбөрт элсэхээр хүсэлт гаргасан иргэнийг “бүртгүүлэгч”, элсэлтийн шалгалт өгч элсэх болзол хангасан бүртгүүлэгчийг “элсэгч”, элсэлтийн цахим бүртгэлийн системийг “МУИС-ийн бүртгэлийн систем” гэнэ. Элсэлтийн үйл ажиллагааг нэгдсэн байдлаар зохион байгуулахаар томилогдсон комиссыг “элсэлтийн комисс”, элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахад оролцох ажилтныг “комиссын гишүүн” гэнэ.
- 1.4. Бүртгүүлэгч бүртгүүлэхээс өмнө энэхүү журамтай танилцах үүрэгтэй.
- 1.5. Энэхүү журам болон элсэлтийн холбоотой нэмэлт мэдээллийг <http://burtgel.num.edu.mn> цахим хуудсанд байрлуулна.
- 1.6. Өмнө эзэмшсэнээс өөр чиглэлээр магистр/докторын зэргийн хөтөлбөрт суралцахыг хүссэн элсэгчид сургалтын агуулгын залгамж, чанарыг хангахад шаардагдах зөрүү хичээлийг мэргэжлийн тэнхмийн санал, Сургалтын нэгдсэн албаны зөвшөөрөл дээр үндэслэн судална. Эдгээр хичээлийн багц цагийг магистр/докторын зэрэг олгох үндсэн хичээлд тооцохгүй.
- 1.7. Элсэлт авах хөтөлбөр, элсэлтийн бүртгэлийн дэс дараалал, элсэлтийн шалгалтын хуваарь өдөр, цаг, байр болон бусад мэдээллийг МУИС-ийн төв байрны гаднах электрон самбар болон бүртгэлийн систем, өдөр тутмын сонин, [www.num.edu.mn](http://graduate.num.edu.mn), <http://graduate.num.edu.mn> цахим хуудсанд байрлуулна.
- 1.8. МУИС-д элсэхийг хүссэн гадаадын харьят иргэдийн асуудлыг тусад нь журмаар зохицуулна.

- 1.9. Энэхүү журмаар зохицуулагдахгүй асуудлыг МУИС-ийн захирлын тушаалаар байгуулагдсан Элсэлтийн комисс шийдвэрлэнэ.

## 2. Бүртгүүлэгчдэд тавих шаардлага

- 2.1. Магистрын хөтөлбөрт тодорхой мэргэжлээр бакалаврын зэрэгтэй, докторын хөтөлбөрт тодорхой мэргэжлээр магистрын зэрэгтэй иргэнийг элсүүлнэ.
- 2.2. Докторын хөтөлбөрт экстернат хэлбэрээр суралцах хүсэлтэй бүртгүүлэгчийг ТДС-ийн сургалтын журмын 6.3.6 заалтаар элсүүлнэ.
- 2.3. Бүртгэлтэй холбоотой төлбөр, тооцоог цахим хэлбэрээр хийнэ /цахим картаар төлбөрийг хэрхэн хийх тухай дэлгэрэнгүй зөвлөмжийг системээс үзнэ үү/.
- 2.4. Бүртгүүлэгч нь системд өөрийн гар утасны дугаар, цахим шуудангийн хаягийг заавал бүртгүүлэх бөгөөд энэ мэдээллийн үнэн зөв оруулсан байдлыг бүртгүүлэгч өөрөө хариуцана.

## 3. Элсэлтийн бүртгэл

- 3.1. Элсэлтийг жилд хоёр удаа авна.
- 3.2. Элсэлтийн бүртгэлийг зөвхөн цахим хэлбэрээр <http://burtgel.num.edu.mn> хаягаар явуулна.
- 3.3. Элсэлтийн бүртгэл дараах хугацаанд явагдана
- Зуны элсэлт 7 дугаар сарын 15-наас 9 дүгээр сарын 15-ны хооронд
  - Өвлийн элсэлт 11 дүгээр сарын 1-нээс 1 дүгээр сарын 1-ний хооронд.
- 3.4. Бүртгүүлэгч нь МУИС-ийн бүртгэлийн системд хувийн мэдээлэл болон нэвтрэх мэдээллээ (цахим шуудангийн хаяг болон нэвтрэх үг) оруулснаар элсэх хүсэлтээ гаргана.
- 3.5. Бүртгүүлэхдээ бүртгэлийн систем дэх анкетыг бөглөж, дараах бичиг баримтуудын эх хувийг цахим хэлбэрээр хавсаргана. Үүнд:
- Иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах баримт бичиг (төрсний гэрчилгээ, гадаад паспорт);
  - Өмнө нь эзэмшсэн боловсролын диплом, түүний хавсралт;
  - Цээж зураг (Зургийн шаардлагыг бүртгэлийн системээс үзнэ үү).
- 3.6. Бүртгүүлэгч хувийн мэдээллээ баталгаажуулсны дараа бүртгүүлэх боломжтой хөтөлбөрийн жагсаалтыг системээс харуулах бөгөөд элсэхийг хүссэн бүрэлдэхүүн сургууль/салбар, хөтөлбөрөө сонгож тэмдэглэнэ.
- 3.7. Элсэхийг хүссэн хөтөлбөрийг сонгосон үед төлбөл зохих төлбөрийн хэмжээ гарах бөгөөд уг мэдээлэлтэй танилцаад төлбөрийг цахим хэлбэрээр хийнэ (Голомт банк, Төрийн банкны төгрөгийн цахим гүйлгээ хийдэг, өөрийн эзэмшдэг эсвэл өөр эзэмшигчийн (эзэмшигчийн зөвшөөрлөөр) картаар төлбөр хийх боломжтой.
- 3.8. Элсэлтийн бүртгэл, шалгалтын хураамж 25000 төгрөг байна.
- 3.9. Бүртгүүлэгч хэдэн ч хөтөлбөрт бүртгүүлж болох боловч зөвхөн нэг хөтөлбөрт элсэх эрх авна.

## 4. Элсэлтийн шалгалт

- 4.1. Бүртгүүлэгч бакалаврын зэргийн боловсролоо МУИС-д эзэмшиж 3-аас дээш голчтой төгссөн бол МУИС-ийн магистрын хөтөлбөрт шалгалтгүйгээр элсэнэ.
- 4.2. Бүртгүүлэгч нь элсэхийг хүссэн магистрын хөтөлбөрт хавсралтад заасан хичээлүүдээс холбогдох шалгалтыг бүрэлдэхүүн сургуулийн санал /Шинжлэх

- ухааны сургуулийн хувьд Байгалийн ухаан, Нийгмийн ухаан, Хүмүүнлэгийн ухаан гэсэн 3 салбарын/-аар өгнө. Шалгалт өгөх хичээлийн нэрийг хавсралтаас үзнэ.
- 4.3. Докторын хөтөлбөрт бүртгүүлэгч нь судалгааны чиглэлийн дагуу 3000 дээш үгтэй эссэ бичиж, ярилцлага өгөх ба эдгээр шалгалтуудын оноог 50%, 50% харьцаагаар тооцно.
- 4.4. Шалгалтыг бүртгэл дууссаны дараах 14 хоногт багтаан Бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба зохион байгуулж, дүнг нэгтгэн гаргаж ~~сургалтын мэдээллийн~~ системд оруулна.
- 4.5. Шалгалт авах өдөр, цаг, байр, шалгалтын талаарх мэдээллийг бүртгэлийн хугацаанд <http://burtgel.num.edu.mn> цахим хуудсанд байршуулна.
- 4.6. Шалгуулагчдад шалгалтын дүнг бүртгэлийн системээр мэдэгдэнэ.
- 4.7. Шалгалтанд авбал зохих нийт онооны 60-аас доошгүй хувийг авсан тохиолдолд МУИС-д элсэх болзول хангасан гэж үзнэ. Шалгалтын нийт оноог дараах байдлаар тодорхойлно. Үүнд:
- Тухайн хөтөлбөрийн хувьд нэг шалгалт авсан бол уг шалгалтын оноо;
  - Тухайн хөтөлбөрийн хувьд хоёр шалгалт авсан бол шалгалтуудын оноог 50%, 50% харьцаагаар тооцно. Өөрөөр хэлбэл, I шалгалтанд авсан оноог 0.5 -аар II шалгалтанд авсан оноог 0.5 -аар үржүүлж нэмнэ.

## 5. Элсэгчийг шалгаруулах ба мэдэгдэх

- 5.1. Бүртгүүлэгчийн шалгалтын нийт оноог хавсралтад заасан шалгалтын харьцааг харгалзан тооцож (4.4-т заасан аргачлалаар тооцож) жагсаан, онооны дарааллаар хяналтын тоонд багтаан элсүүлнэ. Хяналтын тоог жил бүр Бүрэлдэхүүн сургуулиуд, СНА, ТДС хамтран шийдвэрлэнэ.
- 5.2. Хяналтын тоонд багтсан эсэхийг шалгалт дууссаны дараа шалгуулагчид МУИС-ийн бүртгэлийн системээр мэдэгдэнэ.
- 5.3. Хяналтын тоонд багтсан элсэгч элсэх эрхээ авахдаа дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:
- Иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах баримт бичиг (төрсний гэрчилгээ, гадаад паспорт), хуулбарын хамт (ар, өвөр тал нэг нүүрэнд)
  - Өмнө нь эзэмшил боловсролын диплом, хавсралт хуулбарын хамт
  - Цээж зураг 2 хувь, суралцагчийн үнэмлэхний шаардлагад нийцсэн цээж зураг файл хэлбэрээр (аль аль нь сүүлийн 3 сард авахуулсан)
- Эдгээр материалыг битүүмжлэл сайтай хавтсанд хийсэн байна.
- 5.4. Элсэх эрх олгох үед бүртгэлийн мэдээллийг эх бичиг баримтуудтай тулгаж, баталгаажуулна.

## 6. Бусад

- 6.1. Бүртгүүлэгч системд бүртгүүлсэн боловч МУИС-ийн үйл ажиллагаанаас үл хамааран элсэлтийн шалгалтыг өгөөгүй бол бүртгэлийн хураамжийг буцааж олгохгүй.
- 6.2. Элсэх эрх авсан боловч заасан хугацаанд ирж бүртгүүлээгүй /суралцах гэрээ байгуулаагүй/ хүнийг суралцахаас татгалзсан гэж үзэн элсэх эрхийг хүчингүйд тооцно.
- 6.3. Элссэн магистрант, докторант нь суралцаагүй тохиолдолд тухайн хичээлийн жилийн тухайн улирлыг оролцуулан дараалсан 4 улирлын хугацаанд суралцах эрх нь хүчинтэй байна.

- 6.4. Элсэх эрх авсан боловч анги бүрдээгүй тохиолдолд элсэгчид сөөр ойролцоо хөтөлбөрийг санал болгоно. Элсэгч санал болгосон хөтөлбөрөөр суралцахгүй тохиолдолд бүртгэлийн хураамжийг буцаан олгоно.
- 6.5. Элсэлттэй холбоотой бичиг баримтыг хуурамчаар үйлдвэл МУИС-д элсүүлэхгүй бөгөөд хуурамч бичиг баримтаар элссэн нь тогтоогдсон тохиолдолд хасах буюу хуулийн байгууллагад мэдэгдэнэ.
- 6.6. Элсэлтийг цахим хэлбэрээр явуулахад зориулсан цахим хуудасын бүтээн жилийн турш тогтмол ажиллагаатай байж, элсэлтийн талаарх мэдээллээр бүртгүүлэгчдийг хангана.
- 6.7. Цахим бүртгэл явагдаж байх үед МУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиуд хөтөлбөрүүдээ танилцуулах, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг утас, цахим шуудангаар зохион байгуулна.

\*\*\*

\*\*\*

\*\*\*

**МУИС-ийн магистрын хөтөлбөрт оюутан элсүүлэх түр журмын хавсралт**

№	МУИС-ийн Бүрэлдэхүүн сургууль	Сонгох боломжтой хөтөлбөр	Элсэлтийн шалгалт	
			Шалгалт 1 50%	Шалгалт 2 50%
1	Шинжлэх Ухааны Сургууль Байгалийн ухааны салбар	Математик /алгебр, магадлалын онол, анализ, геометр/; Багш, математикийн; Физик; Багш, физикийн; Хими /Байгалийн нэгдлийн хими, Нефтийн хими, Нүүрсний хими, Хүнсний хими, Хими /органик бус хими/; Органик хими, Хүрээлэн буй орчны хими/; Багш, химийн; Биологи /биохими, микробиологи, амьтан судлал, ургамал судлал, биоорганик хими, молекул биологи, биофизик/; Биологи, биотехнологи; Экологи, байгаль хамгаалал; Байгаль орчныг зайнаас тандан судлал ба газарзүйн мэдээллийн систем; Газарзүй; Газрын кадастр; Менежмент, газар зохион байгуулалт; Хот ба бус нутгийн төлөвлөлт; Багш, газарзүй-байгаль шинжлэлийн; Хөрс судлал, агрохими; Геологи; Шатах ашигт малтмалын эрэл хайгуул; Геофизик; Хэрэглээний геофизик	Математик Физик Хими Биологи Газарзүй Геологи	Ярилцлага
2	Шинжлэх Ухааны Сургууль Нийгмийн Ухааны Салбар	Археологи; Нийгэм соёлын антропологи; Сэтгэл судлал; Боловсрол судлал, менежмент; Сэтгүүл зүй; Социологи; Нийгмийн ажил; Улс төр судлал;  Хүн ам зүй; Эдийн засаг; Эдийн засаг, статистик	Нийгмийн шинжлэх ухааны суурь мэдлэгийн шалгалт	Ярилцлага
3	Шинжлэх Ухааны сургууль Хүмүүнлэгийн Ухааны салбар	Хэлний бус: Философи; Шашин судлал; Түүх; Урлаг судлал; Олон улс судлал, монгол судлал  Хэлний: Хэл шинжлэл; Орчуулга, гадаад хэлний; Боловсрол судлал, гадаад хэл, заах арга зүй; Монгол хэл эх бичиг судлал; Монгол хэл, уран зохиол; Утга зохиол судлал;	Нэгдсэн сорилго 100%  Нэгдсэн сорилго 100%	

4	Хэрэглээний Шинжлэх Ухаан Инженерчлэлийн Сургууль	Математик, статистик; Эдийн засаг - математик загварчлал; Математик, хэрэглээний; Электроник, автоматик; Мультимедиа холбооны технологи; Компьютерийн сүлжээ; Физик-электроник, Цөмийн технологи; Сэргээгдэх эрчим хүч; Мэдээллийн технологи; Компьютерийн програм хангамж; Мэдээллийн систем; Менежмент, мэдээллийн системийн; Математик, програм хангамж; Биологи, хэрэглээний /биоинформатик, биохимийн инженерчлэл, биопроцессийн инженерчлэл/; Хүрээлэн байгаа орчны экологи; Байгаль ашиглалт хяналт, үнэлгээ; Хими технологи; Эрдэс материалын хими; Цаг уурын мэдээлэл, прогноз; Ус судлал, усны хими; Ой судлал; Усны менежмент; Нано шинжлэх ухаан; Нано инженерчлэл; Нанобиотехнологи	 УХДСОТГ 0104399	Математик Физик Хими Биологи Газарзүй Мэдээллийн технологи	Ярилцлага
5	Бизнесийн сургууль	Бизнесийн менежмент; Менежмент, маркетингийн; Менежмент, олон улсын худалдаа; Менежмент, гадаад худалдаа, гаалийн; Менежмент, санхүүгийн; Нягтлан бодох бүртгэл; Санхүү, эдийн засаг; Аялал жуулчлалын менежмент			Нэгдсэн сорилго 100%
6	Хууль Зүйн Сургууль	Эрхзүй; Олон улсын эрх зүй			Мэргэжил 100% /Төр эрх зүйн онол/
7	Олон Улсын Харилцаа Нийтийн Удирдлагын Сургууль	Олон улсын харилцаа; Олон улсын эдийн засгийн харилцаа; Нийтийн удирдлага	Доорх сэдвийн аль нэгийг сонгож эсэ бичих 1. Олон улсын харилцааны тулгамдсан асуудал 2. Төрийн захиргааны тулгамдсан асуудал		Ярилцлага

**МУИС-ийн докторын хөтөлбөрт оюутан элсүүлэх түр журмын хавсралт**



№	МУИС-ийн Бүрэлдэхүүн сургууль	Сонгох боломжтой хөтөлбөр <b>УХД0072 9104399</b>
1	Шинжлэх Ухааны Сургууль Байгалийн ухааны салбар	Математик; Багш, математикийн; Физик; Багш, физикийн; Хими; Багш, химийн; Биологи; Экологи, байгаль хамгаалал; Байгаль орчныг зайнаас тандан судлал ба газарзүйн мэдээллийн систем; Газарзүй; Геологи; Геофизик
2	Шинжлэх Ухааны Сургууль Нийгмийн Ухааны Салбар	Археологи; Нийгэм соёлын антропологи; Сэтгэл судлал; Боловсрол судлал, менежмент; Сэтгүүл зүй; Социологи; Нийгмийн ажил; Улс төр судлал; Эдийн засаг
3	Шинжлэх Ухааны сургууль Хүмүүнлэгийн Ухааны салбар	Философи; Шашин судлал; Түүх; Монгол хэл эх бичиг судлал; Монгол хэл, уран зохиол; Урлаг судлал; Утга зохиол судлал; Гадаад хэл, шинжлэл; Олон улс судлал, монгол судлал; Боловсрол судлал
4	Хэрэглээний Шинжлэх Ухаан Инженерчлэлийн Сургууль	Математик, хэрэглээний; Электроник, автоматик; Компьютерийн сүлжээ; Цөмийн технологи; Сэргээгдэх эрчим хүч; Компьютерийн програм хангамж; Цаг уурын мэдээлэл, прогноз; Ой судлал
5	Бизнесийн сургууль	Бизнесийн менежмент
6	Хууль Зүйн Сургууль	Эрхзүй
7	Олон Улсын Харилцаа Нийтийн Удирдлагын Сургууль	Олон улсын харилцаа; Олон улсын эдийн засгийн харилцаа; Нийтийн удирдлага